



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 11

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 сарын 27-ны өдрийн 636 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арвангуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гурвансайхан суманд барьж, ашиглалтад оруулсан Засаг даргын тамгын газрын барилга дээр нэмэлт гэрээгээр хийж гүйцэтгэсэн нийт 10,529,247 /арван сая таван зуун хорин есөн мянга хоёр зуун дөчин долоо/ төгрөгийн өртөгтэй гадна холбооны шугамыг нэмж бүртгэхийг зөвшөөрсүгэй.


2. Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газрын дарга (Б.Энхтуяа)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.2 Тогтоолын биелэлтийг 2023 оны 4 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
11 дүгээр тогтоолын хавсралт



Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын
Тамгын газрын барилга байгууламжийн дансанд нэмж
бүртгэх хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	2021 онд бүртгэлд авсан барилгын дүн	Барилга байгууламжийн дансанд нэмж бүртгэх хөрөнгийн дүн
1	Захиргааны барилга	1,113,094,923	
2	Бохир усны шугам	1,003,296.91	
3	Гадна дулааны шугам	1,329,716.70	
4	Гадна цэвэр усны шугам	45,386.60	
5	Гадна холбооны шугам		10,529,247
Барилга байгууламжийн нийт дүн		1,150,000,000 /нэг тэрбум нэг зуун тавин сая/ төгрөг	